


Дуурайх үгийг хэрэглэсэн
учрыг тайлбарлаж,
хэлзүйн шинжийг
тодорхойлох

VII анги

Хичээлийн зорилго



Үйл хөдлөлийн харагдах байдал буюу дүр байдлыг дүрсэлсэн үг, үйл хөдлөлийн сонсогдох байдал буюу дуу авиаг дүрсэлсэн үгийг тодруулах

1

Дуурайх, дүрслэх үгийн хэлзүйн шинжийг мэдэх

2

Эхээс дуурайх ба дүрслэх үгийг утгаар нь зөв бүлэглэх

3

Үйл ажиллагаа 1. Шүлгийг уншаад, дараах аяллын зураглалыг гаргая.

УЛААНБААТАРААС БЕРЛИН ХҮРТЭЛ

(Төгсгөлөн өгөө.)

Бургалтай өртөөнд бууж амраад
Бүрий гэгээгээр шинэ сарны гэрэлд шогшиж
Хуримтын өртөөнд хүрч
Хоёр шинэ нөхөртэйгөө нийлгэлдэн
Хойд зүгт гангар гунгар хийлцэн урамтай л даахилдав.
Хөвөн цагаан үүл хэсэг хэсгээр нүүгээд
Намрын салхи сэр сэр салхилна.
Баруун хойно Бүргэд уул дүнсийн үзэгдэх бөгөөд...
СССР улсын хилд нэгэнт ормогц
Элдэв зүйл цам гадаадын байдал болов.
Оросын паар тэрэг хөө хөө, тэр тэр гэж таржигнуулсаар
Тэр орой нэгэн тосгонд хүрч хонсо.
Зүүн хойд нурууны дор Үд хот униартаад...
Жолооч хүний нүд сэрвэлээж, исгэрэн ташуурдмагц
Хөглөсөн морины хамар онгоглож, тэмүүлэн давхиад
Тэрэний хонхоо харжигнуулсаар, Сэлэнгийн хөвөөнд очив.
Шөнө унтаад өглөө босож үзвэл
Байгал нуурын хөвөөнд ирээд байна.
Энэ этгээдэд их нуур хягааргүй цэлмийгээд...
Далайн ус гүн өргөн малхийсээр
Цааш хягааргүй тэнгэртэй зөрөглэн залгалджээ.
Сөөрөл шувууд усан дээгүүр жиргэгдэн нисээд
Загас жараахай энд тэнд пол пол хийж байна.
Уралын нуруу гэгч урт бөгөөд алдартай
Ой мод, усан булаг, уурхайн баялаг их юм.
Үдшийн цагт галт тэргэнд суугаад унтсан нь
Өглөө босоход Ленинград хотод ирэв.
Их Нева мөрний хөвөөн дээр очих...
Үдшийн цаг бага онгоцор далайн хөвөөнд очив.
Энэ тэр этгээдээс гуншилдан гүн ган бархиралцаад...
Дөрвөн зүг мэлцийгээд уснаас өөр юм үл үзэгдэх нь сонирхолтой.
Умар зүгээс сэрүүн салхи сэржигнэн салхилаад
Уурын онгоц зомгол мэт далбилзан халбилзвээд
Урагш хойш дэгшин долгионд цохигдон бөмбөрнө.
Шинэ сарны гэрэл туяаран усанд үзэгдэн гэрэлтээд
Олон одон жирэв жарав гийлцэнэ.
Тэртээд улаан туяанд олон гэрэл гилтгэнэх нь
Штетин гэдэг хот ойртож байгаа гэнэ.
Ирэх өглөө эртлэн босож завдаад
Галт тэргэнд сууж Берлиний зүг явав.



Их зохиолч
Д.Нацагдорж
Герман улсад
суралцахаар явахдаа
"Улаанбаатараас
Берлин хүртэл"
(1926.08.27) аян
замын шүлэглэсэн
тэмдэглэлээ бичжээ.

Аяллын товч зураглал



Улаанбаатар

Бургалтайн өртөөнд бууж амраад
Бүрий гэгээгээр шинэ сарны гэрэлд шогшиж

.....
Баруун хойно Бүргэд уул дүнсийн үзэгдэх
бөгөөд

СССР улс



Штетин

1. Улаанбаатараас
Берлин хүртэл
зохиогчийн аяллын
сэтгэгдэл ямар
байсныг
жишээгээр
тайлбарлаарай.
2. Аяллаас ямар,
ямар шинэ
мэдээлэл олж
мэдсэн бэ?

Үйл ажиллагаа 2

- ✦ Хойд зүгт **гангар гунгар** хийлцэн урамтай л давхилдав.
- ✦ Намрын салхи **сэр сэр** салхилна.
- ✦ Оросын паар тэрэг **хөв хөв, тар тар** гэж таржигнуулсаар ...
- ✦ Жолооч хүний нүд **сэрвэлзэж**, исгэрэн ташуурдмагц ...
- ✦ Хөллөсөн морины хамар **онголзож**, тэмүүлэн давхиад ...
- ✦ Тэрэгний хонхоо **харжигнуулсаар**, Сэлэнгийн хөвөөнд очив.
- ✦ Энэ этгээдэд их нуур хязгааргүй **цэлмийгээд**...
- ✦ Далайн ус гүн өргөн **мэлмийсээр**...
- ✦ Саарал шувууд усан дээгүүр **жиргэлдэн** нисээд ...
- ✦ Загас жараахай энд тэнд **пол пол** хийж байна.
- ✦ Энэ тэр этгээдээс **гуншилдан гүн ган** бархиралцаад...
- ✦ Дөрвөн зүг **мэлцийгээд** уснаас өөр юм үл үзэгдэх нь сонирхолтой.
- ✦ Умар зүгээс сэрүүн салхи **сэржигнэн** салхилаад ...
- ✦ Уурын онгоц зомгол мэт **далбилзан халбилзаад** ...
- ✦ Олон одон **жирэв жарав** гийлцэнэ.
- ✦ Тэртээд улаан туяанд олон гэрэл **гилтгэнэх** нь...

Үйл хөдлөлийн харагдах байдал буюу дүр байдлыг дүрсэлсэн үгийг түүж бичье

Сэрвэлзэж, онголзож, цэлмийгээд , мэлмийсээр, мэлцийгээд , далбилзан халбилзаад ,жирэв жарав гилтгэнэх нь

Дүрслэх үг

Дуурайх үг

Үйл хөдлөлийн сонсогдох байдал буюу дуу авиаг дүрсэлсэн үгийг түүж бичье

Гангар гунгар, сэр сэр, хөв хөв, тар тар, таржигнуулсаар, харжигнуулсаар, пол пол, гуншилдан гүн ган бархиралцаад, сэржигнэн

Дүрслэх дуурайх үг нь өгүүлбэрт ямар үгтэй холбогдож байгааг ажиглая.

- Хойд зүгт **гангар гунгар** хийлцэн урамтай л давхилдав.
- Намрын салхи **сэр сэр** салхилна.
- Оросын паар тэрэг **хөв хөв, тар тар** гэж таржигнуулсаар...
- Жолооч хүний нүд **сэрвэлзэж**, исгэрэн ташуурдмагц...
- Хөллөсөн морины хамар **онголзож**, тэмүүлэн давхиад...
- Тэрэгний хонхоо **харжигнуулсаар**, Сэлэнгийн хөвөөнд очив.
- Умар зүгээс сэрүүн салхи **сэржигнэн** салхилаад

Дуурайх дүрслэх үгс нь хойшоогоо дандаа үйл үгтэй холбогдож байгааг анхаараарай.

Үйл хөдлөлийн дуу чимээ, дүр байдлыг зааж, үйлийн дүр байдлыг тодруулж, үйлийн шинжийг зааж байна.

Дуурайх үгсийн
утгын ангилал

Дуурайх
үг

Авиа
дуурайх

Хүн амьтны дуу дуурайх \ хүд хүд,
жир жир , жив жув \

Юмс үзэгдлийн дуу авиа дуурайх
\ хан ян, тор тор \

Дүрс
дуурайх

Хүн амьтны дүрс дуурайх \ гэдэс
гэдэс, годос годос, сартага сартага \

Юмс үзэгдлийн дүрс дуурайх\ хага,
хуга, цоо, бут, бяц \

Дүрслэх, дуурайх үгсийн хэлзүйн шинж

Дэвтэртээ тэмдэглээрэй.

Хүн, юмс үзэгдлийн үйл хөдлөл, дүр байдлын хэлбэр дүрс, дуу авиаг ялган нэрлэж, нэр ба үйл үгэнд үндсээрээ холбогддог үгсийг дуурайх үг гэнэ.

Дуурайх ба дүрслэх үг нь :

- Үйлийн байдлыг илэрхийлдэг.
- Дүрслэх, дуурайх үгс нь өгүүлбэрт язгуураар эсвэл дагавар авч үйлшиж, үйлийн дүр байдлыг заадаг
- Үйлийн шинжийг тодотгож , өгүүлэгчийн сэтгэлийн өнгө аясыг илтгэж, үйлийг тоочин дүрслэх хэрэглүүр болдог.

Үйл ажиллагаа 3.

Тодруулсан үгсийн дүрслэлийн
утгын ялгааг харьцуулан
тайлбарлая



- Таржигнуулсаар – харжигнуулсаар
Хатуу юмны харшилдан дуугарах дуу чимээг ойролцоо утгатай үгээр илэрхийлсэн.
- Цэлмийгээд- мэлцийгээд- мэлмийсээр
Нүдэнд торох зүйлгүй өргөн, уудам цэлгэр харагдах байдлыг ойролцоо утгатай үгээр илэрхийлсэн.
- Далбилзан – халбилзаад
Халбис далбис хөдлөх хөдөлгөөнийг ойролцоо утгатай үгээр илэрхийлсэн.

Үйл ажиллагаа 4


Дараах үгсийг утгаар нь бүлэглээд, тус бүр 2 өгүүлбэр зохион бичээрэй.

Бүлэглэх үгс:

жив жув, жирэв зурав, жин жан, найтаг тайтаг, налчиг балчиг, пал пул, пий пай, пэд пад, сүр сар, таль туль, тар няр, өм цөм, тар тур, ээн уун, там тум, хан ян, гял цал, хар хүр, хан ян, татга ятга, гэдэн годон, ярс ярс, тор тор, лүг лүг, гялав

Авиа дуурайх үг	Дүрс дуурайх дуурайх үг
жив жув , жин жан,	Жирэв зурав, найтаг тайтаг,

Дүгнэлт



1

Дуурайх үг нь хүн, юмс үзэгдлийн үйл хөдлөл, дүр байдлын хэлбэр дүрс, дуу авиаг ялган нэрлэдэг.

2

Дуурайх үг нь нэр ба үйл үгэнд үндсээрээ холбогддог.

3

Дүрслэх, дуурайх үгс нь өгүүлбэрт язгуураар эсвэл дагавар авч үйлшиж, үйлийн дүр байдлыг заадаг

4

Үйлийн шинжийг тодотгож , өгүүлэгчийн сэтгэлийн өнгө аясыг илтгэж, үйлийг тоочин дүрслэх хэрэглүүр болдог.

5

Үйл хөдлөлийн харагдах байдал буюу дүр байдлыг дүрсэлсэн үг, үйл хөдлөлийн сонсогдох байдал буюу дуу авиаг дүрсэлсэн үгийг тодруулж утгаар нь бүлэглэж сурлаа.

Анхаарал тавьсанд баярлалаа